



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар A/43

Пионер толгой

Г Дархлаажуулалтын ажил зохион  
байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг дахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт, Олон Улсын худалдааны хорио цээрт шүлхий өвчний сэжигтэй бүсэд нутаглаж буй нийт малчдын мал сүрэгт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 72 цагийн хугацаанд яаралтай зохион байгуулсугай.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг яаралтай зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажилд мал сүргээ бүрэн хамруулж, хашаа хороо, хүн хүчээр хангаж, дархлаа тогтох хүртэл 21 хоногийн хугацаанд нүүдэл хийхгүй байх, дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулах ажлыг багийн Засаг дарга нарт, төлөвлөгөөт дархлаажуулалтын ажилд мал сүргээ хамруулахаас зайлсхийсэн, санаатай болон санамсаргүй байдлаар шилжилт хөдөлгөөн хийсэн нөхцөлд хариуцлага тооцохыг хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Л.Дуламдорж)-д үүрэг болгосугай.

4. Мал, амьтны гоц халдварт Олон Улсын худалдааны хорио цээрт шүлхий өвчний дархлаажуулалт хийсэн бүс нутгаас 14 хоногийн хугацаанд мал, амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргахгүй байхыг анхааруулж Мал эмнэлгийн гэрчилгээ бичихгүй байхыг Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн эмч нарт, хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Л.Дуламдорж) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтын ажилд шаардлагатай зүү тариур, халдварт хамгааллын хувцас, хоол хүнс, шатахууны зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг

нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай)-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.



Сумын Засаг даргын 2022 оны 03...  
дугаар сарын 09 -ны өдрийн 11/43 тоот  
захирамжийн..... дугаар хавсралт

## ДАРХЛААЖУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ

### Шар-Усны чиглэлд:

Ажлын хэсгийн ахлагч: Э.Хас-Очир (Мал эмнэлгийн Улсын байцаагч)

Гишүүд: Б.Бат-Эрдэнэ (Малын их эмч)

П.Тогтохжаргал ( Санхүү албаны дарга)

Ш.Нархүү (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Г.Эрдэнэ-Очир (Биеийн тамирын арга зүйч)

Д.Бат-Эрдэнэ (Жолооч)

Д.Мөнхчулуун (Давааны ам 2 дугаар багийн Засаг  
дарга)

А.Бямба-Очир (Цагдаа)

Б.Лувсаншийрэв (Цэнгэл 1 дүгээр багийн Засаг  
дарга)

М.Ариунсан (Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн  
технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн )

А.Баяртогтох (Үйлчлэгч)

### Хар-Ус Үнхэлцэгийн чиглэлд:

Ажлын хэсгийн ахлагч: н.Содномбалжир (Малын их эмч)

Гишүүд: Д.Болд-Аюуш (Буга 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Рэнцэндагва (Тохижилт үйлчилгээний ажилтан)

Б.Дэлгэрдалай (Нягтлан бодогч)

Ц.Номин-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

Б.Сүмбэрзул (Олон нийтийн цагдаа)

Б.Баттулга (Хөвийн ам 4 дүгээр багийн засаг дарга)

Ч.Батцэцэг (Пионер толгой 5 дугаар багийн засаг  
дарга)